

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ

2006

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Чулуун зэвсгийн үеийг 3 томоохон үед хуваадаг аль нь чулуун зэвсгийн зөв үечлэл вэ? (1 оноо)
A. Хуучин, дунд, шинэ чулуун зэвсэг B. Бүдүүлэг, завсын, боловсронгуй чулуун зэвсэг
C. Болхи бүдүүлэг, хөгжингүй чулуун зэвсэг D. Бүдүүлэг завсын шинэ чулуун зэвсэг
E. Хуучин бүдүүлэг хөгжингүй чулуун зэвсэг
2. Монгол нутагт 800 мянган жилийн тэртээ эртний хүн амьдарч байсныг юугаар нотолдог вэ? (1 оноо)
A. Эртний хүний яс B. Хөдөлмөрийн багаж хэрэгсэл
C. Хадны сүг зураг D. Булш бунхан
E. А болон D зөв
3. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуйн дурсгал аль үеийн гол дурсгал вэ? (1 оноо)
A. Хуучин чулуун зэвсэг B. Дунд чулуун зэвсэг C. Хүрэл зэвсгийн үе
D. Төмөр зэвсгийн түрүү үе E. Хүннү
4. Эртний хүмүүсийн хамгийн анх эрхэлж байсан аж ахуй аль нь вэ? (1 оноо)
A. Мал аж ахуй B. Газар тариалан C. Нүүдлийн мал аж ахуй
D. Ан гөрөө E. Газар тариалан мал аж ахуй
5. Аль нь МЭӨ /НТӨ/ II мянганы II хагаст хамаарах вэ? (2 оноо)
A. МЭӨ XXVI-XXIX зуун B. МЭӨ XIX-XVI зуун C. МЭӨ XIV-XI зуун
D. МЭӨ XXIV-XXI зуун E. МЭӨ IX-VI зуун
6. Аль нь хүн төрөлхтний нийгмийн зохион байгуулалтын анхны хэлбэр болох эхийн эрхт овгийн гол шинжийг илэрхийлж байна вэ? (1 оноо)
A. Хүн сүргийн нэг хэлбэр
B. Хүн сүргээрээ амьдардаг учраас нэгдсэн бүлэг хүмүүс
C. Төрийн зохион байгуулалтын анхны хэлбэр
D. Цэргийн ардчиллын хэлбэр
E. Цусан төрлийн холбоотой хүмүүсийн нэгдэл
7. Монгол нутагт өргөн тархсан хиригсүүр нь аль үед хамарагдах дурсгал вэ? (1 оноо)
A. Хуучин чулуун зэвсэг B. Дунд чулуун зэвсэг C. Шинэ чулуун зэвсэг
D. Хүрэл зэвсгийн үе E. Хүннү
8. Монгол нутагт өргөн дэлгэрсэн буган хөшөөнд ихэвчлэн юу дүрсэлсэн байдаг вэ? (1 оноо)
A. Морь унасан болон морин тэрэгтэй хүмүүс
B. Ан хийж байгаа хүмүүс
C. Буга агнаж байгаа хүмүүс, нар сар зэр зэвсэг
D. Нар сар, байгаль дэлхий, хүн, зэр зэвсэг
E. Нар сар, буга зэр зэвсэг
9. Эртний хүмүүс чулуун зэвсгийн хэд хэдэн үеийг дамжин хөгжжээ. Чулуун зэвсгийн үеийг хуучин чулуун зэвсэг дунд чулуун зэвсэг шинэ чулуун зэвсгийн үе гэсэн 3 томоохон үед хуваагдана. Энэ ангиллыг хийхдээ юуг гол шалгуур болгосон вэ? (1 оноо)
A. Нийгмийн зохион байгуулалтанд гарсан өөрчлөлт
B. Аж ахуйд шинэ шинэ салбар үүссэнийг үндэслэн
C. Овгийн байгууллын хөгжлийн түвшинг харгалзан
D. Чулуун зэвсэг хийх технологид гарсан өөрчлөлт
E. Эхийн болон эцгийн эрхт ёсны хөгжлийг харгалзан
10. “Газар бол улсын үндэс” хэмээх төр ёсны уламжлалын зарчмыг хэн үндэслэсэн бэ? (1 оноо)
A. Модунь B. Таньшихуай C. Хабул хан
D. Моюнхуай E. Чингис хаан
11. Аль нь монгол нутагт оршин байсан эртний улс биш вэ? (1 оноо)
A. Түрэг B. Сяньби C. Тугуухунь /тогон/ D. Уйгур E. Жужан /Нирун/
12. Монгол нутагт оршин тогтнож байсан эртний улсуудын нэг Түрэгийн хаант улс хэдийд оршин тогтнож байсан вэ? (1 оноо)
A. МЭ /НТ/ 330-555 он B. МЭ 555-745 он C. МЭ 745-840 он
D. МЭ 840-930 он E. МЭ 930-1125 он
13. Өгөгдсөн эхийг анхааралтай уншина уу.
“Сурвалжтанууд малаар төдийгүй арилжааны ашиг, дайны олзоор өмч хөрөнгө, нэр хүнд, нөлөөгөө бэхжүүлдэг байлаа. Дайнаар бусдын мал хөрөнгийг дээрэмдэх, эрхшээлдээ оруулах явдал жирийн

- хэрэг байв. Төрөл бус хэд хэдэн аймаг цэргийн хүчирхэг удирдагчийн захиргаанд нэгдэж нийгмийн зохион байгуулалтын шинэ хэлбэрийг бий болгожээ. Тэдний дунд ноёлогч аймаг бий болж, аймгуудын зонхилогчдын зөвлөнөөс тэргүүнээ сонгодог болов”. Дээрх эхэд нийгмийн зохион байгуулалтын аль хэлбэрийн талаар өгүүлж байна вэ? (2 оноо)
- | | | |
|------------|--------------------|---------------------|
| A. Төр улс | B. Эхийн эрхт овог | C. Эцгийн эрхт овог |
| D. Аймаг | E. Аймгийн холбоо | |
14. Төв Азийн монгол түрэг манж угсааны нүүдэлчдийн хэлийг нэг язгуураас үүсэн салсан гэж үздэг. Тэрхүү өвөг хэлийг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
- | | | |
|---------------|-------------|---------|
| A. Индо-европ | B. Фин-угор | C. Согд |
| D. Алтай | E. Хянган | |
15. Хүннүгээс уламжлалтай Аравтын тогтолцооны үндсэн шинж юу вэ? (2 оноо)
- | | |
|------------------------------|---|
| A. Цэргийн зохион байгуулалт | B. Засаг захиргааны зохион байгуулалт |
| C. Иргэний зохион байгуулалт | D. Цэрэг засаг захиргааны зохион байгуулалт |
| E. В болон С зөв | |
16. “Эргүнэ гүн”-ийн домгийн гол агуулга юу вэ? (2 оноо)
- | | |
|--|--|
| A. Алунгоо таван хүүдээ алдарт сургаалаа хэлсэн тухай | |
| B. Ах дүү 2 муудалцан ах нь аймаг олноо дагуулан нүүж Тогон улсыг байгуулсан тухай | |
| C. Түрэг Монгол аймгуудын хоорондох нэгэн удаагийн дайнд Монголчууд ялагдаж алс бөглүү газар очиж суусан тухай | |
| D. Бертө чину, Гоо марал хоёр тэнгис далайг гэтлэн нүүж ирсэн тухай | |
| E. Алагдах дайсангүй энх амгалангийн орон Эргүнэ-Гүн болох тухай | |
17. XI-XII зууны үед язгуурын монгол аймгууд нирүн ба дарлигин гэсэн хоёр бүлэгт хуваагддаг байжээ. Дарлигин аймгууд гэж ямар овог аймгийг хэлдэг байсан вэ? (1 оноо)
- | | |
|--|--|
| A. Добу мэргэний бэлэвсэн хатан Алунгоогийн гурван хөвгүүдийн удмаас үүсэлтэй ноёлогч овог аймгууд | |
| B. “Эргүнэ гүн”-д очсон Нукуз, Хиян хоёр овгоос үржин олон болсон “Эргүнэ гүн”-ийн монгол аймгууд | |
| C. Хамаг Монголоос бусад ханлиг аймгууд | |
| D. Хамаг Монголын ханлигийн бүрэлдэхүүн багтдаг бүх овог аймгууд | |
| E. Хабул ханы удмыхан | |
18. “Турван голын Монголчууд” гэж ямар аймаг ханлигийг нэрлэдэг вэ? (1 оноо)
- | | | |
|-----------|-----------------|-----------|
| A. Хэрэйд | B. Мэргид | C. Найман |
| D. Татар | E. Хамаг монгол | |
19. Хамаг Монголын ханлигийн анхны хаан хэн бэ? (1 оноо)
- | | | |
|------------|------------|-----------|
| A. Хабул | B. Амбагай | C. Хотула |
| D. Тэмүжин | E. Есүхэй | |
20. Тэмүжин хэдэн онд хамаг Монголын ханлигийг дахин сэргээн, Чингис цолтойгоор хамаг Монголын ханлигийн ханаар өргөмжлөгдсөн бэ? (1 оноо)
- | | | | | |
|------------|------------|------------|------------|------------|
| A. 1162 он | B. 1280 он | C. 1189 он | D. 1202 он | E. 1206 он |
|------------|------------|------------|------------|------------|
21. Их Монгол улсын үед хаан өргөмжлөх, харь оронтой дайтах, найрамдах зэрэг төрийн онц чухал хэргийг ямар байгууллага хэлэлцэн шийдвэрлэдэг байсан вэ? (1 оноо)
- | | | |
|------------------------|------------------------|----------|
| A. Сэцдийн зөвлөл | B. Их хуралдай | C. Илдэч |
| D. Язгууртны хуралдаан | E. Алтан ургийн зөвлөл | |
22. Чингис хаан их монгол улсыг байгуулаад улсын го ван /улсын ван/-аар хэнийг томилсон вэ? (1 оноо)
- | | | |
|-----------|-------------|--------------|
| A. Боорчи | B. Мухуйлай | C. Шихихутаг |
| D. Зэв | E. Зэлэм | |
23. Өгөгдсөн эхийг анхааралтай уншаад 23, 24 дэх асуултад хариулна уу.
 «Чингис хаан (баруун зүг) байлдаанд мордоод, Тангуд улсын Бурханд элч явуулж хэлүүлсэн нь: “Баруун гар чинь больё гэж чи хэлсэн биш үү? Сартаул улсад алтан аргамжаа таслуулаад би хариу авахаар мордов. Баруун гар болж морил” гэж илгээв. Бурхан үг хэлэхийн урьд Аша Хамбу өгүүлрүүн: “Хүч хүрэхгүй бол хаан юунд болов” гээд туслах цэрэг өгсөнгүй омогтой их үг хэлж элчийг буцаажээ». Дээрх эхэд “алтан аргамж” гэж юуны тухай өгүүлж байна вэ? (2 оноо)
- | | | |
|--------------------|-----------------|--------------|
| A. Гадаад худалдаа | B. Алт эрдэнэс | C. Мал сүрэг |
| D. Элчин харилцаа | E. Цэрэг дайчид | |
24. Чингис хаан ямар улс руу хийсэн аян дайндаа Тангудын Бурхан хааныг Баруун гар болж морил хэмээн хүч хавсруулахаар элч илгээсэн тухай дээрх эхэд өгүүлж байна вэ? (1 оноо)
- | | | |
|--------------|-----------|--------------|
| A. Алтан улс | B. Хорезм | C. Хар хидан |
| D. Энэтхэг | E. Хятад | |

35. Монголд шарын шашин дэлгэрсний хамгийн гол эерэг талыг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Олон сүм хийд байгуулагдан, уран барилга, уран баримлын гайхамшигт дурсгалуудыг бүтээсэн
 - B. Олон эрдэмтэн мэргэд төрөн гарч, буддизмын олон ухаанаар бүтээлээ туурвисан
 - C. Хүмүүсийн оюун санааг чөлөөлсөн
 - D. Энэтхэг, Түвдийн соёл нэвтрэн, Монголын соёлыг Хятадын соёлоос хамгаалах үүрэг гүйцэтгэсэн
 - E. Дотоодын дайн самуун зогссон
36. Манжаас тогтоосон хуулиар монголын малчин ардуудыг суман ард, хамжлага ард, шавь ард, хэмээн гурав хуваан хамжлагачлахаар тогтоожээ. Хамжлага ард нь хэний хамжлага вэ? (2 оноо)
- A. Монголын ноёд язгууртнуудын
 - B. Манжийн хааны /төрийн/
 - C. Манжийн амбаны
 - D. Хутагт хувилгаадын
 - E. С ба D зөв
37. XIX зууны II хагасаас Манж Чин улс Монголд шинэ засгийн бодлого (ШЗБ)-ыг хэрэгжүүлж эхэлжээ. Үүний улмаас Монголд гадаадын, ялангуяа Хятадын худалдаа мөнгө хүүллийн капитал хүчтэй нэвтэрч, ихээхэн хөгжсөн. Хятадын худалдаа мөнгө хүүллийн капитал нь Монголд эерэг болон сөрөг нөлөө үзүүлжээ. Монголын түүхэнд гүйцэтгэсэн гол эерэг нөлөө нь юу вэ? (2 оноо)
- A. Монголын эдийн засгийг хөгжүүлсэн
 - B. Шинээр олон үйлдвэр аж ахуйн газар байгуулагдсан
 - C. Монгол дэлхийн зах зээлтэй холбогдож, таваар мөнгөний харилцаа хөгжсөн
 - D. Хятад, Монголын харилцаа сайжирсан
 - E. Монголын ард түмний аж байдал сайжрахад нөлөөлсөн
38. 1911 онд Монголчууд ямар улсын ноёрхлыг түлхэн унагааж, төрийн тусгаар тогтнолоо сэргээсэн бэ? (1 оноо)
- A. Хятад
 - B. Манж Чин улс
 - C. Орос
 - D. Дундад иргэн улс
 - E. Дундад улс
39. 1911.12.29-нд Монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн, Богд Жибзундамба хутагтыг хаан ширээнд өргөмжиж, 5 яамыг байгуулжээ. Гадаад яамны тэргүүн сайдаар хэнийг томилсон вэ? (1 оноо)
- A. Да лам Цэрэнчимэд
 - B. Сайн ноён хан Намнансүрэн
 - C. Бэйс Гомбосүрэн
 - D. Чин ван Ханддорж
 - E. Гүн Цэрэндорж
40. 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Монголын тусгаар тогтнолын асуудлыг хэрхэн шийдсэн вэ? (2 оноо)
- A. Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
 - B. Нийт Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
 - C. Нийт Монголд Хятадын харьяаны автономит эрх олгосон
 - D. Зөвхөн Ар Монголд Хятадын харьяаны автономит эрх олгосон
 - E. Нийт Монголыг Хятадын харьяаны жирийн муж болгосон
41. Консулын дэнжийн нууц бүлгээнийг хэн санаачлан байгуулсан вэ? (1 оноо)
- A. Д.Бодоо
 - B. Д.Сүхбаатар
 - C. С.Данзан
 - D. Х.Чойбалсан
 - E. Д.Догсом
42. Манай улсад жил бүрийн 11 сарын 26-ыг улс тунхагласны баярын өдөр болгон тэмдэглэдэг. Түүхэн ямар үйл явдалтай холбогдуулан энэ баярыг тэмдэглэдэг вэ? (2 оноо)
- A. 1911.11.26-нд Богд хаант монгол улс байгуулагдсан
 - B. 1912.11.26-нд гадаадын 9 улсад нот бичиг илгээн тусгаар тогтнолоо зарласан
 - C. 1921.11.26-нд гадаадын 9 улсад нот бичиг илгээн тусгаар тогтнолоо зарласан
 - D. 1924.11.26-нд анхдугаар үндсэн хуулийг баталж, бүгд найрамдах байгуулал тогтсон
 - E. 1945.11.26-нд Орос, Хятад 2 улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
43. Манай улс хэдийд хэмжээт эрхт (цаазат) хаант төрийн байгуулалтай байсан бэ? (2 оноо)
- A. 1911-1919 он
 - B. 1911-1921 он
 - C. 1911-1924 он
 - D. 1921-1924 он
 - E. 1911-1915 он
44. Өгөгдсөн эхийг анхааралтай уншаад, асуултанд хариулна уу. “Монгол улсын Богд хаан Жибзундамба хутагтад шарын шашны бүх хэргийг хязгааргүй эрхлэх эрхийг үлдээж, Ардын засгийн газраас тогтоон явуулах аливаа хууль дүрмийг Богд хаантанд айлтгэн сонсгох хэдий ч хууль дүрмийг Богд зөвхөн нэг удаагаас илүү буцаах, хүчингүй болгох эрхгүйг онцлон заажээ”. Ямар баримт бичгийн (эрх зүйн актын) гол агуулгын талаар дээрх эхэд өгүүлж байна вэ? (2 оноо)
- A. Үндсэн хууль
 - B. Тангаргийн гэрээ
 - C. Засгийн газрын гэрээ
 - D. Богдын эрхийг хэмжээлсэн дүрэм
 - E. Ван гүнгүйдийн эрх хэмжээний дүрэм

Боловсролын Үнэлгээний Төв

45. “Бусдыг мөлжихгүйгээр хэм тэгш баяжигтун” уриаг хэдийд, ямар үзэл баримтлагчид дэвшүүлсэн бэ?
(2 оноо)
- A. 1920-иод оны II хагаст үндэсний ардчилсан үзэл баримтлагчид
 - B. 1929-1932 оны үед зүүнтнүүд
 - C. 1920-иод оны эхэн үед капитализмын замаар замнагчид
 - D. 1911-1919 онд Монголын удирдагчид
 - E. 1940-өөд онд Чойбалсан
46. “1927 онд Коминтерн Монголын тухай тусгай тогтоол гаргаж, түүнийгээ хэрэгжүүлэхийг Монголын удирдагчдаа шаарджаэ. Монголын удирдагч Ц.Дамбадорж, Б.Цэрэндорж, Н.Жадамба зэрэг хэд хэдэн хүн Коминтерний дээрх тогтоолыг эсэргүүцэж тодорхой тайлбарласан хариуг 1927 оны тавдугаар сард НТХ-ны нарийн бичгийн дарга Г.Гэлэгсэнгэ, хэлтсийн эрхлэгч Б.Дугаржав нараар Коминтернд хүргүүлжээ”. Монголын удирдагчид Коминтерний тогтоолыг эсэргүүцсэн шалтгааныг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ?
(2 оноо)
- A. Зөв зүйтэй тогтоол байсныг Монголын удирдагчид ойлгоогүй
 - B. Тогтоолын ач холбогдлыг Монголын удирдагчид дутуу ухаарсан
 - C. Монголын удирдагчдын санаанд нийцэгүй
 - D. Монголын нөхцөлд таарахгүй байсан
 - E. А болон В хариулт зөв
47. Өгөгдсөн эхийг анхаарлтай уншина уу. «“Мөнөөхөн ардыг мөлжиж, хөрөнгө зоорь хураасан ван, гүн, хутагт, сүм, жас, баячууд, шинэ хөрөнгөтөн, панзчин нарын хэтэрхий хөрөнгөжих замыг хязгаарлах, ... тэдгээрийн хөрөнгийг бүр мөсөн буюу заримыг нь хураах” тухай шийдвэр гаргасны дагуу хар, шар “феодал” агсадын хөрөнгө хураах үйл явдал эхэлжээ». Дээрх эхэд өгүүлж байгаа “феодал” агсадын хөрөнгийг хураах ажиллагаа хэдийд болсон бэ?
(2 оноо)
- A. 1921-1924 он
 - B. 1924-1928 он
 - C. 1929-1932 он
 - D. 1932-1934 он
 - E. 1924-1926 он
48. 1933 онд Сайд нарын Зөвлөлийн тогтоол гаргаж, улмаар “Төрөөс шашныг тусгаарлах тухай хууль”-аар 18 нас хүрээгүй хүүхдийг хийдэд шавилан суухыг хориглосны гол учир юу вэ?
(2 оноо)
- A. Хүүхдийн эрхийг хамгаалах
 - B. Хийдэд шавилан суугчдын тоог цөөрүүлж, улмаар сүм хийдийг шахах
 - C. Сургуулийн хүүхдийн тоог нэмэгдүүлэх
 - D. Цэргийн тоог нэмэгдүүлэх
 - E. А болон D хариулт зөв
49. Өгөгдсөн эхийг анхааралтай уншинаау. “1937.8.24-нд ЗХУ-ын ДХАК(ДЯЯ)-ын орлогч сайд М.П.Фриновский, БХЯ-ны орлогч сайд Смирнов нар Монголд ирж, Японоос Монголыг эзлэх төлөвлөгөө гэгчийг Монголын удирдагчдад танилцуулж, “хуйвалдаан” гэгч хэрэгт холбогдсон 115 хүний нэрсийн жагсаалтыг ДЯЯ-ны сайд Х.Чойбалсанд гардуулсан байна. Ингээд 1939.9.10-ны шөнө ЗХУ-ын ДХАК-ын газраас ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу цэрэг, төр захиргаа, соёлын салбарын ажилтан 69 хүнийг нэгэн зэрэг баривчилснаар Монгол орныг нийтэд нь хамарсан их залхаан цээрлүүлэлт, нийтээр хоморголон хэлмэгдүүлэх ажиллагаа эхэлсэн байна”. Эхийг уншаад дараах дүгнэлт хийжээ. Аль дүгнэлт нь тухайн үеийн түүхэн нөхцөл байдлыг илүү оновчтой илэрхийлж байна вэ?
(2 оноо)
- A. Монголд Японы тагнуулын байгууллага байсныг илрүүлсэн
 - B. Монголд Зөвлөлтийн эсрэг “хуйвалдаан” хийх зорилготой нууц байгууллага байсан
 - C. Монголын ДЯЯ муу ажиллаж байсан
 - D. Монгол дахь хэлмэгдүүлтийг ЗХУ-аас санаачлан зохион байгуулсан
 - E. А ба В хариулт зөв
50. «1937 оны 9 дүгээр сараас 1939 оны 4 дүгээр сар хүртэл “Онцгой бүрэн эрхт комисс” ажиллахдаа 51 удаа хуралдаж, 25824 хүний “хэргийг хэлэлцэж” 20471 хүнийг хуулийн дээд хэмжээгээр хороож, 5103 хүнийг 10 жил, 240 хүнийг арав хүртэлх жилийн хугацаагаар хориход шийдвэрлэжээ. Зөвхөн нэг удаагийн хурлаар 40-1278 хүртэлх хүний хэргийг “хэлэлцэж” байв». Дээрх эхийг уншаад дараах дүгнэлтийг хийжээ. Аль дүгнэлт нь тухайн бодит байдлыг илүү оновчтой илэрхийлж байна вэ?
(2 оноо)
- A. Монголын шүүхийг “Онцгой бүрэн эрхт комисс” гэж нэрлэдэг байсан
 - B. Монголд Японы тагнуулын байгууллагын сүлжээ байсан
 - C. Монголд хувьсгалын эсэргүү, Зөвлөлтийн эсрэг “нууц бүлэглэл” байсан
 - D. Шүүхээр гэм бурууг нь тогтоолгүй, хууль ёс, хүний эрхийг ноцтой зөрчин, хэлмэгдүүлж байсан
 - E. А болон C хариулт зөв

51. 1945.10.20-нд манай улс даяар бүх нийтийн санал хураалт анх удаа явагджээ. Бүх нийтийн санал хураалтыг ямар асуудлаар явуулсан бэ? (2 оноо)
- A. Монголын тусгаар тогтолын асуудлаар
 - B. ЗХУ-д нэгдэх асуудлаар
 - C. Японд дайн зарлах асуудлаар
 - D. Хятадад нэгдэх асуудлаар
 - E. Бүх нийтийн сонгуулийн асуудлаар
52. 1949 оны Улсын IX Их Хурлаас “Ардын аж ахуйтанд малаа өсгөх төлөвлөгөө тогтоох тухай” хуулиар ардын аж ахуйтан бүрд малын too толгойг өсгөх төлөвлөгөөг жил бүр өгч байх болов. Үүнийг дагалдан малчид малаасаа төвөгшөөн “ялтай мал” гэж үзэх болсны учир юу вэ? (2 оноо)
- A. Төлөвлөгөөт малаас мах, ноос, сүү албадан гаргуулж, төлөвлөгөө биелүүлээгүй малчдыг хуулиар шийтгэж байснаас
 - B. Малаа өсгөн, олон малтай болсон малчдыг “нударган” хэмээн үзэж, малыг нь улсын өмч болгон хураах шийдвэр гарснаас
 - C. Малчид хот суурин газар амьдрах сонирхолтой болж, малаа маллах дургүй байснаас
 - D. Нэгдлийн малыг хорогдуулвал хариуцлага хүлээдэг байснаас
 - E. С болон D хариулт зөв
53. 1951 онд УИХ-ын сонгуулийг анх удаа шинэ сонгуулийн системээр явуулав. 1951-1990 оны үеийн депутатуудыг “томилолтын депутат”, “албан тушаалын депутат” хэмээн нэрлэн шүүмжилдгийн учир юу вэ? (2 оноо)
- A. Бүх шатны хурлын депутатуудыг томилдог байсан
 - B. Ардын Их Хурлын депутатууд аймаг бүхий төлөөллөөс бүрддэг байсан
 - C. Дээрээс өгсөн нэрийн дагуу ямар ч өрсөлдөгчгүй ганц хүнийг дэвшүүлж, сонгодог байсан учир
 - D. Зөвхөн ажилчин, малчин хүн л депутат болдог байсан учир
 - E. Зөвхөн тэргүүний ажилчин хүн депутат болдог байсан учир
54. «1958 оны 3 дугаар сарын МАХН-ын XIII их хурал “ойрын гурван жилд ардын аж ахуйтны ихэнхийг сайн дурын зарчмын үндсэн дээр хоршоолон нэгтгэх нь зүйтэй” гэсэн шийдвэр гаргасны дагуу нэгдэлжих хөдөлгөөн орон даяар өрнөжээ. 1959 оны эцэс гэхэд нийт ардын аж ахуйтны 99,7 хувь нь нэгдэлжих хөдөлгөөнд хамрагдажээ». Ардын аж ахуйтнууд богино хугацааны дотор малаа нийгэмчилж, төлөвлөснөөсөө богино хугацаанд нэгдэлжих хөдөлгөөн ялсны үндсэн гол шалтгаан юу вэ? (2 оноо)
- A. Нэгдэлжих хөдөлгөөн нь эдийн засгийн ба эдийн засгийн бус албадлага, ухуулан “сэнхрүүлэх” зэрэг олон талын шахалтаар компаничлан явагдсан
 - B. Нэгдэлжих хөдөлгөөн сайн дурын зарчмын үндсэн дээр явагдсан
 - C. Ардын аж ахуйтнуудын олонхи нь нэгдэлд элсэн орох дуртай байсан
 - D. Ардын аж ахуйтнуудын олонхи нь нэгдлийн давуу талыг ойлгон малаа нийгэмчлэх сонирхолтой байсан
 - E. С болон D хариулт зөв
55. “БНМАУ-ын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол... МАХН мөн” гэсэн 1960 оны үндсэн хуулийн заалтын мөн чанарыг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Нэг намын ноёрхлыг гүнзгийрүүлж, нам төвтэй улс төрийн тогтолцоо тогтох эрх зүйн үндэс болсон
 - B. МАХН-ын үүргийг дээшлүүлсэн
 - C. Төрийн үүргийг бууруулсан
 - D. Ганц намын тогтолцоотой байх эрх зүйн үндэс болсон
 - E. МАХН-аас өөр нам байгуулагдах эрх зүйн үндсийг үгүйсгэсэн
56. “1960-1980-аад онд МАХН-ын Марксист-Ленинист шинж чанар, БНМАУ-ын капиталист бус замын түүхэн туршлагыг нэгтгэн дүгнэх чиглэлээр Монгол, Зөвлөлтийн зохиогчдын хамтын бүтээл, мөн эрдэмтэн судлаачдын олон арван, нэгэн сэдэвт зохиол, өгүүлүүд нийтлэгдэж байжээ”. Дээрх эхийг уншаад дараах дүгнэлтүүдийг хийжээ. Аль дүгнэлт нь тухайн үеийн нийгмийн мөн чанарыг илүү үнэн зөв илэрхийлж байна вэ?
- A. Тухайн үеийн Монголд нийгмийн онолын сэтгэлгээ өндөр түвшинд хөгжсөн
 - B. Монголын нийгмийн онолын сэтгэлгээ нь хүн төрөлхтний сэтгэлгээний хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан
 - C. БНМАУ-ын капиталист бус хөгжлийн түүхэн туршлага нь нийгмийн хөгжлийн шилдэг загвар мөн
 - D. Марксизм-Ленинизмыг цорын ганц үнэн зөв сургаал хэмээн үзэж, нийгмийн онолын сэтгэлгээг үзэл сурталжуулж байсан
 - E. А болон B хариулт зөв
57. 1992 оны Үндсэн хуулинд зааснаар аль субъект нь хууль санаачлах эрхтэй вэ? (2 оноо)
- A. Засгийн газар
 - B. Олон нийтийн байгууллага
 - C. Монгол улсын иргэн
 - D. Үндсэн хуулийн цэц
 - E. Хөдөлмөрчид

Боловсролын Үнэлгээний Төв

58. Манай улсыг хэдийд БНМАУ гэж нэрлэж байсан бэ? (2 оноо)
- A. 1921 -1990 он
 - B. 1924-1992 он
 - C. 1924-1990 он
 - D. 1921 оноос одоог хүртэл
 - E. 1924 оноос одоог хүртэл

ХОЁРДУГААР ХЭСЭГ

59. Дараах түүхийн дурсгалууд аль үед хамаарахыг тохируулна уу. (A, B,C, D, E тус бүрт харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу).
- | | |
|------------------------------------|-------------------------|
| A. Дорнодын Тамсагбулагийн дурсгал | 1. Хуучин чулуун зэвсэг |
| B. Культегиний гэрэлт хөшөө | 2. Шинэ чулуун зэвсэг |
| C. Ховдын Хойд Цэнхэрийн агуй | 3. Хүннүгийн үе |
| D. Ноён уулын соёл | 4. Түрэгийн үе |
| E. Дөрвөлжин булаш | 5. Хүрэл, төмрийн үе |
60. Монголчууд түүхэндээ олон бичиг үсэг зохион хэрэглэж байжээ. Ямар бичиг үсгийг хэн зохиосныг тохируулна уу. (A, B, C тус бүрт харгалзах утгыг 1, 2, 3-аас сонгоно уу).
- | | |
|-------------------|---------------------------|
| A. Дөрвөлжин үсэг | 1. Өндөр гэгээн Занабазар |
| B. Тод үсэг | 2. Зая бандид Намхайжамц |
| C. Соёмбо үсэг | 3. Пагва лам |

ХУВИЛБАР В

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Археологийн сүүлийн үеийн судалгаагаар Монгол нутагт хэдий үеэс хүн амьдарч эхэлсэн нь тогтоогдсон вэ? (1 оноо)
- | | |
|---|---------------------------------|
| A. 800 мянган жилийн тэртээгээс | B. Нэг сая жилийн тэртээгээс |
| C. 500 мянган жилийн тэртээгээс | D. 300 мянган жилийн тэртээгээс |
| E. Нэг сая 500 мянган жилийн тэртээгээс | |
2. Дундговь аймгийн Гурван сайханы Ярын дурсгал аль үеийн гол дурсгал вэ? (1 оноо)
- | | | |
|----------------------------|-----------------------|----------------------|
| A. Хуучин чулуун зэвсэг | B. Дунд чулуун зэвсэг | C. Хүрэл зэвсгийн үе |
| D. Төмөр зэвсгийн түрүү үе | E. Хүннуу | |
3. Эртний хүмүүс чулуун зэвсгийн хэд хэдэн үеийг дамжин хөгжжээ. Чулуун зэвсгийн хамгийн сүүлийн шатыг /үеийг/ юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
- | | | |
|-----------------------|----------------------------|-----------------------------|
| A. Дунд чулуун зэвсэг | B. Эцсийн чулуун зэвсэг | C. Төгсгөлийн чулуун зэвсэг |
| D. Шинэ чулуун зэвсэг | E. Хөгжингүй чулуун зэвсэг | |
4. Аль нь МЭӨ /НТӨ/ I мянганы II хагаст хамаарах вэ? (2 оноо)
- | | | |
|---------------------|---------------------|--------------------|
| A. МЭӨ XVI-XIX зуун | B. МЭӨ XIX-XVI зуун | C. МЭӨ XIV-XI зуун |
| D. МЭӨ IV-I зуун | E. МЭӨ IX-VI зуун | |
5. Монгол нутагт өргөн тархсан дөрвөлжин булаш нь аль үед хамарагдах дурсгал вэ? (1 оноо)
- | | | |
|-----------------------------|-----------------------|-----------------------|
| A. Хуучин чулуун зэвсэг | B. Дунд чулуун зэвсэг | C. Шинэ чулуун зэвсэг |
| D. Хүрэл, төмөр зэвсгийн үе | E. Хүннуу | |
6. Эртний хүмүүс чулуун зэвсгийн хэд хэдэн үеийг дамжин хөгжжээ. Чулуун зэвсгийн үеийг хуучин чулуун зэвсэг, дунд чулуун зэвсэг, шинэ чулуун зэвсгийн үе гэсэн 3 томоохон үед хуваадаг. Энэ ангиллыг хийхдээ юуг гол шалгуур болгосон вэ? (1 оноо)
- | | |
|--|--|
| A. Нийгмийн зохион байгуулалтанд гарсан өөрчлөлт | |
| B. Аж ахуйд шинэ шинэ салбар үүссэнийг үндэслэн | |
| C. Овгийн байгууллын хөгжлийн түвшинг харгалзан | |
| D. Чулуун зэвсэг хийх технологид гарсан өөрчлөлт | |
| E. Эхийн болон эзгийн эрхт ёсны хөгжлийг харгалзан | |
7. Төр улс үүсэхийн өмнө нийгмийн зохион байгуулалтын хэлбэр юу вэ? (1 оноо)
- | | | |
|--------------------|---------------------|----------|
| A. Эхийн эрхт овог | B. Эзгийн эрхт овог | C. Аймаг |
| D. Аймгийн холбоо | E. А ба В зөв | |
8. Монгол нутагт өргөн тархсан буган хөшөөнд бугыг хэрхэн яаж дурсэлсэн байдаг вэ? (1 оноо)
- | | | |
|--------------------------|----------------------|-----------------------------|
| A. Зөвхөн бодит байдлаар | B. Зөвхөн загварчилж | C. Бодитой болон загварчилж |
| D. Улаан зосоор зурж | E. Бэхээр зурж | |

9. Монгол нутагт үүссэн анхны төрт улс Хүннү хэзээ байгуулагдсан вэ? (1 оноо)
 А. МЭӨ 198 он Б. МЭӨ 209 он С. МЭӨ 109 он
 Д. МЭ 109 он Е. МЭ 93 он
10. Түрэгийн хаад, жанжин нарт зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээс ямар бичгээр /үсгээр/ бичигдсэн байдаг вэ? (1 оноо)
 А. Монгол бичиг Б. Руни бичиг С. Уйгур бичиг
 Д. Согд бичиг Е. Уйгуржин монгол бичиг
11. Доор өгөгдсөн үгүүдийг ямар шалгуураар А ба В хэсэгт хуваан бичсэн байна вэ?
 А) Аравтын систем, хууль дээдлэх, төрийн билэгдэл, татварын тогтолцоо
 Б) Хэв заншил баримтлах, хамтын өмч, цусан төрөл, эхийн эрхт ёс (2 оноо)
 А. Овог ба аймгийн зохион байгуулалт Б. Соёлын хэлбэрийн ялгаа
 С. Зан заншлын ялгаа Д. Угсаа гарлын ялгаа
 Е. Төр ба овгийн зохион байгуулалт
12. Өгөгдсөн эхийг анхааралтай уншина уу. “Овгийн дотор эрэгтэйчүүдийн нөлөө тэргүүлэх байр суурьтай болж, хүүхдүүд эцгээрээ овоглодог болов. Улмаар эцгийн эрх нөлөөн дор зохион байгуулагдсан, ясан төрлийн холбоонд үндэслэсэн нийгмийн зохион байгуулалтын шинэ хэлбэр үүсчээ”. Дээрх эхэд нийгмийн зохион байгуулалтын ямар хэлбэрийн тухай өгүүлж байна вэ? (2 оноо)
 А. Эхийн эрхт овог Б. Эцгийн эрхт овог С. Аймаг
 Д. Аймгийн холбоо Е. Төр улс
13. Төв Азийн Монгол, Түрэг, Манж угсааны нүүдэлчдийн хэлийг нэг язгуураас үүсэн салсан гэж үздэг. Тэрхүү өвөг хэлийг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
 А. Индо-Европ Б. Фин-Угор С. Согд
 Д. Алтай Е. Хянган
14. Хүннүгийн үеэс уламжлалтай Аравтын тогтолцооны үндсэн шинж юу вэ? (2 оноо)
 А. Цэргийн зохион байгуулалт Б. Засаг захиргааны зохион байгуулалт
 С. Иргэний зохион байгуулалт Д. Цэрэг-засаг захиргааны зохион байгуулалт
 Е. В болон С хариулт зөв
15. Дунху нар Монголчуудтай угсаа гарлын ямар холбоотой вэ? (2 оноо)
 А. Монгол хэлтэн, Монголчуудын эртний дээд өвөг
 Б. Түрэг хэлтэн, угсаа гарлын холбоогүй
 С. Манж хэлтэн, угсаа гарлын холбоогүй
 Д. Монголчуудтай угсаа гарлын холбоогүй ч хожим бүрэлдэхүүнд нь орсон
 Е. Монгол хэлтэн, угсаа гарлын холбоогүй
16. “Эргүнэ гүн”-ийн домгийн гол агуулга юу вэ? (2 оноо)
 А. Алунгоо таван хүүдээ алдарт сургаалаа хэлсэн тухай
 Б. Ах дүү хоёр муудалцан, ах нь аймаг олноо дагуулан нүүж Тогон улсыг байгуулсан тухай
 С. Түрэг, Монгол аймгуудын хоорондох нэгэн удаагийн дайнд Монголчууд ялагдаж, алс бөглүү газар очиж суусан тухай
 Д. Бөртө чину, Гоо марал хоёр тэнгис далайг гэтлэн нүүж ирсэн тухай
 Е. Алалдах дайсангүй энх амгалангийн орон “Эргүнэ гүн” болох тухай
17. XI-XII зууны үед язгуурын Монгол аймгууд ямар хоёр бүлэгт хуваагддаг байсан бэ? (1 оноо)
 А. Аймаг ба Улс Б. Ойн ба Талын С. Нирун ба Дарлигин
 Д. Тайчууд ба Салжууд Е. Хиян ба Никуз
18. Хамаг Монголын ханлиг хаагуур нутаглаж байсан бэ? (1 оноо)
 А. Онон, Орхон, Сэлэнгийн сав Б. Хөлөн, Буйр нуураар
 С. Хэрлэн, Онон, Туулын сав Д. Халх голын сав нутаг
 Е. Орхоны адаг, Сэлэнгийн дунд бие
19. Хамаг Монголын ханлигийн эхний гурван хангуудын хан суусан цаг хугацааны дарааллыг ол. (2 оноо)
 А. Хабул, Хотула, Амбагай Б. Хабул, Амбагай, Хотула
 С. Хотула, Хабул, Амбагай Д. Амбагай, Хабул, Хотула
 Е. Хотула, Амбагай, Хабул
20. Хэдэн онд Онон мөрний хөвөөнд Монгол ноёдын Их хуралдай хуралдаж, Их Монгол улс байгуулагдсаныг даяар олонд тунхаглан зарлаж, Чингис хааныг Их Монгол улсын их хаанаар өргөмжилсөн бэ? (1 оноо)
 А. 1189 он Б. 1196 он С. 1202 он
 Д. 1204 он Е. 1206 он
21. Чингис хаан Их Монгол улсыг байгуулаад улсын Их Заргачаар хэнийг томилсон бэ? (1 оноо)
 А. Боорчи Б. Мухулай С. Шихихутаг
 Д. Зэв Е. Зэлэм

22. Өгөгдсөн эхийг анхааралтай уншина уу.

“Монгол цэрэг Словакийг туулж, Дорнод Чехийг эзэлж, Адриатын тэнгис хүргэл Их хаан нас барсан мэдээ иржээ. Батхаан байлдааныг зогсоон нутгийн зүг жолоо залжээ. Байлдааны явцад Бат, Гүюгтэй эвдрэлцэхэд Их хаан Батад зөвийг өгсөн билээ. Гэвч Гүюг түүнийг хүлээн зөвшөөрөхгүй хэвээр байсан юм. Батын хувьд шинэ хаанд хэнийг сонгох нь ихээхэн учир холбогдолтой байсан болон удаан хугацааны аян дайнд монгол цэргүүд ядарч байсан нь байлдааны ажиллагааг зогсоон, цэргээ буцаан татах шийдвэр гаргахад нөлөөлжээ”. Дээрх эхэд ямар Их хаан (хэн) нас барсан тухай өгүүлж байна вэ? (2 оноо)

A. Чингис B. Өгөдэй C. Мөнх D. Хубилай E. Тулуй

23. Өгөгдсөн эхийг анхааралтай уншаад 23, 24 дахь асуултад хариулаа уу. «Чингис хаан (баруун зүг) байлдаанд мордоод, Тангуд улсын Бурханд элч явуулж хэлүүлсэн нь: “Баруун гар чинь болъё гэж чи хэлсэн биш үү? Сартал улсад алтан аргамжаа таслуулаад би хариу авахаар мордов. Баруун гар болж морил” гэж илгээв. Бурхан үг хэлэхийн урьд Аша Хамбу өгүүлрүүн: “Хүч хүрэхгүй бол хаан юунд болов” гээд туслах цэрэг өгсөнгүй омогтой их үг хэлж элчийг буцаажээ». Дээрх эхэд “алтан аргамж” гэж юуны тухай өгүүлж байна вэ?

A. Гадаад худалдаа B. Алт эрдэнэс C. Мал сүрэг
D. Цэрэг дайчид E. Элчин харилцаа

24. Чингис хаан ямар улс руу хийсэн аян дайндаа Тангудын Бурхан хааныг “Баруун гар болж морил” хэмээн хүч хавсруулахаар элч илгээсэн тухай дээрх эхэд өгүүлж байна вэ? (2 оноо)

A. Алтан улс B. Хорезм C. Хар Кидан D. Энэтхэг E. Хятад

25. Монгол бичгийн хамгийн эртний дурсгал аль нь вэ? (1 оноо)

A. Мөнх хааны гэрэлт хөшөө B. Чингисийн чулууны бичиг C. Цогтын хадны бичиг
D. Алтан товч E. Монголын нууц товчоо

26. Юань улсын сүүлчийн хаан хэн бэ? (1 оноо)

A. Тогоонтөмөр B. Лигдэн C. Аюушридар
D. Есөнтөмөр E. Хайсанхүлэг

27. Буддын шашин монгол нутагт нийт гурвантаа дэлгэрсэн ажээ. Дундах буюу хоёр дахь дэлгэрэлт хэдийд эхэлсэн бэ?

A. Хүннү B. Жужан (Нирун) C. XIII зууны II хагас
D. XVI зууны II хагас E. Түрэг

28. Монгол уламжлалаар эцгийн гол голомтыг аль хөвгүүн нь өвлөн залгамжлах давуу эрхтэй вэ? (1 оноо)

A. Ахмад хүү B. Отгон хүү C. Аль ч хүү болно
D. Эцгийн нэр заасан (гэрээсэлсэн) хүү E. Дунд хүү

29. Монголын түүхэнд XIV зууны сүүлчээс XVII зууныг улс төрийн бутралын үе гэж нэрлэдэг. Улс төрийн бутрал болсон үндсэн гол шалтгаан юу вэ? (2 оноо)

A. Хятадын Мин улсын хагалан бутаргах бодлого, үйл ажиллагаа
B. Хаад, ноёдын дарлал хэрээс хэтэрч, дааж давшгүй алба татвар оногдуулах болсны улмаас ард олны бослого тэмцэл байнга гарах болсон нь улс орныг түйлдүүлсан
C. Эдийн засгийн хувьд бэхжин бие даах чадвартай болсон язгууртан ноёдын улс төрийн талаар тусгаарлах гэсэн эрмэлзэл, тэмцэл
D. Олон жил үргэлжилсэн ган, суд нь улс орны эдийн засгийг доройтуулсан
E. Эзэн хааны алдаатай буруу бодлогын уршиг

30. Улс төрийн бутралын үед алтан ургийн биш нэг хүн хаан ширээнд суусан. Тэр хаан хэн бэ? (1 оноо)

A. Тогоон B. Эсэн C. Адай D. Аругтай E. Мандуул

31. Батмөнх Даян хаан улс төрийн бутралыг даван туулж, бүх Монголыг нэгэн захиргаанд нэгтгэж чадсан билээ. Энэ үеийн талаар түүхэн сурвалжуудад “Гар газар, хөл хөсөр” байсан үе гэж тэмдэглэсэн нь ямар утгыг илрэхийлж байна вэ?

A. Дайн дажингүй, амар тайван байсан
B. Олон жил дараалан ган суд болж, мал сүрэг ихээр хорогдсоноос хийх ажилгүй болсон
C. Худалдаа гар урлал цэцэглэн хөгжсөн
D. Гар урлалд шинэ техник, технологи нэвтэрч ажил хөнгөвчилсөн
E. Мал сүрэг ихээр өсөж, хүмүүсийн амьжиргаа сайжирсан

32. Доорх хариултуудаас аль нь улс төрийн бутралын үеийн “түмэн” хэмээх засаг захиргааны нэгжийг илүү оновчтой тодорхойлж байна вэ? (2 оноо)

A. 10 мянган цэрэг гаргах үүрэг бүхий засаг захиргааны нэгж
B. 10 мянган хүнээс бүрдсэн засаг захиргааны нэгж
C. Аравт, зуут, мянгат, түмт гэсэн 10-тын системийн нэг нэгж
D. Ноёдын том эзэмшил
E. Хэд хэдэн түмтээс бүрдэх их түмт

33. Түүхийн сурвалжуудад улс төрийн бутралын үеийн тухай өгүүлэхдээ хэрэглэдэг “дөчин, дөрвөн 2” хэмээх хэллэг ямар утгыг илэрхийлдэг вэ? (2 оноо)
- A. Эзэн харьяатын ёс
 - B. Мал сүргийн харьцаа
 - C. Зүүн, баруун Монгол
 - D. Ар, Өвөр Монгол
 - E. Цэргийн зохион байгуулалт
34. 1639 онд Халхын ноёд Ширээ Цагаан нуур хэмээх газар чуулж, Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг 5 настайд нь Халх Монголын буддын шашны тэргүүнээр өргөмжилжээ”. Энэ үйл явдалтай холбоотой нэгэн ойг одоо Монголчууд тэмдэглэдэг. Энэ юунд зориулсан ямар ой вэ? (2 оноо)
- A. Шашин дэлгэрсний ой
 - B. Шашины албан ёсны тэргүүнтэй болсны ой
 - C. Богдын шавь үүссэний ой
 - D. Улаанбаатар хот байгуулагдсаны ой
 - E. Хархорум хот байгуулагдсаны ой
35. 1640 онд Тарвагатайн Улаан бураа хэмээх газар Халх, Ойрад, Хөх нуур, Ижил мөрний Монголчуудыг төлөөлсөн том ноёдын чуулган болсон. Чуулганы гол үр дүнг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Монгол Ойрадын их цаазыг баталсан
 - B. Халх журам хуулийг баталсан
 - C. Түшээт хан, Засагт ханы ноёдиг хооронд нь эвлэрүүлсэн
 - D. Халх, Ойрад хоёр бие даасан улс болохоо харилцан хүлээн зөвшөөрсөн
 - E. Манжид дагаар орох шийдвэр гаргасан
36. Монголд XVI зууны II хагасаас буддын шашин хурдан хугацаанд хүчтэй дэлгэрч эхэлжээ. Энэ удаа буддын шашин хүчтэй дэлгэрэх болсон үндсэн гол шалтгааныг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Төрөөс лам нарын эрх дархыг хуульчлан бэхжүүлж дэмжсэн
 - B. Бөөгийн хойлоглох ёсыг халж, бөө мөргөлийг хориглосон
 - C. Улс төрийн бутралыг даван туулж, нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэхийн тулд шашин дэлгэрүүлж, оюун санааны хувьд нэгтгэх бодлого явуулсан
 - D. Монголын ноёд язгууртнууд ард олны бослого тэмцэл, эсэргүүцлийг намжаахын тулд буддын шашны энэрэнгүй үзлийг дэлгэрүүлэхийг зорьсон
 - E. Түвдийн буддын шашны шарын болон улааны урсгал Монголд өөрсдийн урсгалыг дэлгэрүүлэхээр өрсөлдөж байсан
37. Манжаас тогтоосон хуулиар Монголын малчин ардуудыг суман ард, хамжлага ард, шавь ард хэмээн гурав хуваан хамжлагачлахаар тогтоожээ. Суман ард нь хэний хамжлага вэ? (2 оноо)
- A. Монголын ноёд язгууртнуудын
 - B. Тайж нарын
 - C. Хутагт хувилгаадын
 - D. Van, гүнгийн
 - E. Манжийн хааны (төрийн)
38. XIX зууны II хагасаас Манж Чин улс Монголд шинэ засгийн бодлого (ШЗБ)-ыг хэрэгжүүлж эхэлжээ. Монголд хэрэгжүүлсэн ШЗБ-ын мөн чанарыг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Монголыг хөгжүүлэх
 - B. Монголд оруулах Хятадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
 - C. Монгол дахь бусад гадаад орны капиталиг шахан зайлзуулах
 - D. Монголыг Оросоос тусгаарлах
 - E. Монголыг шууд колоничлох, хятадчилах
39. Манж Чин улсын ноёрхлыг түлхэн унагааж, шинэ тутам байгуулагдсан Монгол улс төрийн хэлбэрийн хувьд ямар улс байсан бэ? (4 оноо)
- A. Бүгд найрамдах улс
 - B. Хэмжээт эрхт хаант улс
 - C. Үндсэн хуульт хаант улс
 - D. Хэмжээгүй эрхт хаант улс
 - E. В ба С хариулт зөв
40. Богдын засгийн газар 1913 онд таван замын цэргийг илгээн, цэргийн жанжнаар манлай баатар Дамдинсүрэнг томилжээ. Таван замын цэргийн гол зорилго юу вэ? (2 оноо)
- A. Олноо өргөгдсөн Монгол улсын хилийг хамгаалах
 - B. Олноо өргөгдсөн Монгол улсын хилд халдан ирсэн Хятад цэрэгтэй байлдах
 - C. Өвөр Монголыг чөлөөлөх
 - D. Ховд хот, Ховдын хязгаарыг чөлөөлөх
 - E. А ба В хариулт зөв
41. 1913 оны Орос Хятадын гэрээгээр (Бээжингийн тунхаглалаар) Монголын тусгаар тогтнолын асуудлыг хэрхэн шийдэхээр харилцан тохиролцсон бэ? (2 оноо)
- A. Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөр болсон
 - B. Нийт Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөр болсон
 - C. Нийт Монголд Хятадын харьяаны автономит эрх олгохоор болсон
 - D. Зөвхөн Ар Монголд Хятадын харьяаны автономит эрх олгохоор болсон
 - E. Нийт Монголыг Хятадын харьяаны жирийн муж болгохоор болсон

Боловсролын Үнэлгээний Төв

42. Зүүн хүрээний нууц бүлгэмийг хэн санаачлан байгуулсан бэ? (1 оноо)
A. Д.Бодоо B. Д.Сүхбаатар C. С.Данзан
D. Х.Чойбалсан E. Д.Догсом
43. Манай улсад жил бурийн 3 сарын 18-ыг цэргийн баярын өдөр болгон тэмдэглэдэг. Түүхэн ямар үйл явдалтай холбогдуулан энэ баярыг тэмдэглэдэг вэ? (2 оноо)
A. 1911.3.18-нд Хужирбулангийн цэргийн анги байгуулагдсан
B. 1913.3.18-нд Таван замын цэргийг илгээсэн
C. 1914.3.18-нд Хятадын цэргийг хиар цохисон
D. 1921.3.18-нд Хиагтыг чөлөөлсөн
E. 1924.3.18-нд Үндэсний арми байгуулсан
44. 1921 оны хувьсгалын дараа хийсэн нийгмийг ардчилан өөрчлөх арга хэмжээнүүдээс аль нь нийгмийн хувьсгалын шинжтэй үндсэн гол арга хэмжээ вэ? (2 оноо)
A. Орон нутгийн засаг захиргааг ардчилах B. Хуучны эрүү шүүлтийг халах
C. Улсын түр цагийн хурал байгуулах D. Хамжлагын харилцааг халах
E. Аймгуудын нэрийг өөрчилж, газар усны нэрээр нэрлэх
45. Коминтерны зүгээс намын зүүн жигүүрийнхнийг дэмжин, Үндэсний ардчилсан үзэл баримтлагчдыг “баруунтанд” хэмээн буруутгаж, “зүүнтнүүд”-ийг засгийн эрхэнд гаргах үйл ажиллагааг зохион байгуулсны гол учир шалтгаан юу вэ? (2 оноо)
A. Монгол орныг хөгжүүлэх
B. Монгол Зөвлөлтийн харилцааг сайжруулах
C. Монголын нам, төрийн бодлогын алдааг засах
D. Өөрийн талыг дуулгавартай баримтлагч дэглэмийг монголд тогтоох
E. Хятадын аюулаас урьдчилан сэргийлэх
46. Зүүний алдаа завхралын үе гэж хэдий үеийг нэрлэдэг вэ? (1 оноо)
A. 1929-1932 он B. 1924-1928 он C. 1924-1932 он
D. 1921-1928 он E. 1932-1939 он
47. “1934 оны үед хүрээ хийдийн дэргэдэх дацангууд ба сүмд 18000 гаруй 18 нас хүрээгүй хөвгүүд шавилан сууж байсан бол улсын сургуульд нийтдээ 5000 орчим хүүхэд суралцаж байлаа”. Дээрх эхийг уншаад дараах дүгнэлтүүдийг хийжээ. Аль нь тухайн үеийн бодит байдлыг илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
A. Улсын сургуулийн сургалт муу байсан
B. Сүм хийдийн дацангудын сургалт сайн байсан
C. Сүм хийдийн нөлөө их байсан
D. Сүм хийдэд хүүхдийг хүчээр сургадаг байсан
E. А ба В хариулт зөв
48. “БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид, Ардын Сайд Нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас “Онцгой бүрэн эрхт комисс”-ыг гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулж даргад Х. Чойбалсан, гишүүдэд Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Д.Лувсаншарав, Шүүх Яамны сайд Г.Цэрэндорж нарыг оруулжээ”. “Онцгой бүрэн эрхт комисс” гэж ямар байгууллага байсан бэ? (2 оноо)
A. Тухайн үед Монголын шүүхийг “Онцгой бүрэн эрхт комисс” гэж нэрлэдэг байсан
B. Хууль бусаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж, үй олноор хилсээр хэлмэгдүүлсэн байгууллага
C. Улсын батлан хамгаалах хүчийг оновчтой зохион байгуулах зорилгоор байгуулагдсан байгууллага
D. Дотоодын болон хилийн цэрэг, цагдаа, хуулийн зэрэг хүчний байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий онцгой байгууллага
E. Намаас явуулах үзэл суртлыг гардан хэрэгжүүлдэг байгууллага
49. БНМАУ Манж-Го улстай 1935-1937 онуудад хэлэлцээр хийж, Манжуурын бага хурал хэд хэдэн үе шаттай болжээ. Уг хэлэлцээр ямар асуудлыг хэлэлцсэн бэ? (2 оноо)
A. Хоёр тал харилцан бие биенийхээ тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх
B. Эдийн засаг, худалдаа, соёлын хамтын ажиллагаагаа хөгжүүлэх
C. Харилцан элчин сайдын яамдаа байгуулах
D. Хилийн будилаан, маргаантай газар нутгийн асуудал
E. Дайны үйл ажиллагааг намжаан, “гал” зогсоох
50. “Хувьсгалт Монгол” танкийн цуваа, “Монгол ард” нисэх онгоцны эскадрилийг ямар зорилгоор байгуулсан бэ? (2 оноо)
A. Японы түрэмгийлээс эх орноо хамгаалах
B. Халх голын дайны үед эх орноо хамгаалах
C. Чөлөөлөх дайны үед өвөр Монголчуудаа чөлөөлөх
D. Дэлхийн II дайны үед Зөвлөлтийн ард түмэнд туслах
E. А болон В хариулт зөв

51. 1945.10.20-нд манай улс даяар бүх нийтийн санал хураалт анх удаа явагджээ. Бүх нийтийн санал хураалтыг ямар асуудлаар явуулсан бэ ? (2 оноо)
- A. Монголын тусгаар тогтолын асуудлаар
 - B. Японд дайн зарлах асуудлаар
 - C. ЗХУ-д нэгдэх асуудлаар
 - D. Хятадад нэгдэх асуудлаар
 - E. Бүх нийтийн сонгуулийн асуудлаар
52. 1949 оны Улсын IX Их Хурлаас “Ардын аж ахуйтанд малаа өсгөх төлөвлөгөө тогтоох тухай” хуулиар ардын аж ахуйтан бүрд малын too толгойг өсгөх төлөвлөгөөг жил бүр өгч байх болов. Үүнийг дагалдан малчид малаасаа төвөгшөөн “ялтай мал” гэж үзэх болсны учир юу вэ? (2 оноо)
- A. Төлөвлөгөөт малаас мах, ноос, сүү албадан гаргуулж, төлөвлөгөө биелүүлээгүй малчдыг хуулиар шийтгэж байснаас
 - B. Малаа өсгэн, олон малтай болсон малчдыг “нударган” хэмээн үзэж, малыг нь улсын өмч болгон хураах шийдвэр гарснаас
 - C. Малчид хот суурин газар амьдрах сонирхолтой болж, малаа маллах дургүй байснаас
 - D. Нэгдлийн малыг хорогдуулвал хариуцлага хүлээдэг байснаас
 - E. С болон D хариулт зөв
53. Ардуудыг нэгдэлд элсүүлэх хурлыг олон цагаар зарим үед хэд хоногоор үргэлжлүүлэн хийж чилээж залхаан элсэн орохоор нэрээ бичүүлсэн хүмүүсийг хурлаас гаргадаг, нэгдэлд ороогүйг нь суулгасаар байдаг явдал олон байжээ. Нэгдэлд ороогүй хүмүүсийг элдвээр хяхан хавчих явдал нийтлэг байв”. Дээрх эхийг (жишээг) уншаад дараах дүгнэлтийг хийжээ. Аль дүгнэлт нь тухайн үеийн бодит байдлыг (ардын аж ахуйтныг нэгдэлжих хөдөлгөөнд хамруулахдаа хэрэглэсэн аргыг) илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Нэгдэлжих хөдөлгөөн сайн дурын үндсэн дээр явагдсан бөгөөд дээрх жишээ нь бодит байдалд нийцэхгүй
 - B. Нэгдэлжих хөдөлгөөн үндсэндээ сайн дурын үндсэн дээр явагдсан бөгөөд ганц нэг газар дээрх зарчим зөрчигдөж байсны жишээ юм
 - C. Нэгдэлжих хөдөлгөөн нь эдийн засгийн ба эдийн засгийн бус албадлага, ухуулан “сэнхрүүлэх” зэрэг олон талын шахалтаар компанийлан явагдсан
 - D. Ардын аж ахуйтнуудын олонхи нь нэгдлийн давуу талыг ойлгон малаа нийгэмчлэх сонирхолтой байсан
 - E. А болон B хариулт зөв
54. «1960 оны Үндсэн хуулинд БНМАУ бол “ажилчид, хоршоолсон ардууд, хөдөлмөрч сэхээтний социалист улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн” гэж тус улсын шинж чанар, ангийн бүрэлдэхүүнийг тодорхойлсноор “ажилчин анги, хоршоолсон ардууд, хөдөлмөрч сэхээтэн” гэсэн гурвалсан холбоогоор нийгмийн бүтцийг томьёолох болжээ». Доорх хариултуудаас аль нь “Хоршоолсон ард” хэмээх томьёоллыг илүү оновчтой илэрхийлж байна вэ ? (2 оноо)
- A. Үйлдвэр хоршооллын ажилчид
 - B. МААМС-ын ажилчид
 - C. Газар тариаланчид
 - D. Хувийн жижиг аж ахуйтан малчид
 - E. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн
55. “1966-1990 оны хооронд БНМАУ-ын Ардын Их Хурлын сонгуулийг 7 удаа хийжээ. Олон удаагийн сонгуулийн дүнгээс үзэхэд сонгогчдын 99.9 хувь нь сонгуульд оролцож, 99.98 хувиас дээш нь нэр дэвшигчийн төлөө саналаа өгдөг байжээ”. Дээрх эхийг уншаад дараах дүгнэлүүдийг хийжээ. Аль дүгнэлт нь тухайн үеийн нийгмийн үнэн мөн чанарыг илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Монголын ард түмэн эв нэгдэлтэй байгааг илэрхийлж байна
 - B. Сонгууль ардчилсан зарчмаар явагддаг байсан
 - C. Сонгуулийн ардчилал ёс төдий болж, авторитари дэглэм гүнзгийрсэн
 - D. Монголын ард түмний улс төрийн оролцоо сайн, төрийн дээд эрх ард түмний гарч байсан
 - E. Иргэн бурийн дэмжлэгийг авч чадахууц хүн депутатад нэр дэвшдэг байсан
56. “1960-1980-аад онд МАХН-ын Марксист-Ленинист шинж чанар, БНМАУ-ын капиталист бус замын түүхэн туршлагыг нэгтгэн дүгнэх чиглэлээр Монгол, Зөвлөлтийн зохиогчдын хамтын бүтээл, мөн эрдэмтэн судлаачдын нэгэн сэдэвт олон арван зохиол, өгүүллүүд нийтлэгдэж байжээ”. Дээрх эхийг уншаад дараах дүгнэлтийг хийжээ. Аль дүгнэлт нь тухайн үеийн нийгмийн мөн чанарыг илүү үнэн зөв илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Тухайн үеийн Монголд нийгмийн онолын сэтгэлгээ өндөр түвшинд хөгжсөн
 - B. Монголын нийгмийн онолын сэтгэлгээ нь хүн төрөлхтний сэтгэлгээний хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан
 - C. БНМАУ-ын капиталист бус хөгжлийн түүхэн туршлага нь нийгмийн хөгжлийн шилдэг загвар мөн
 - D. Марксизм-Ленинизмыг цорын ганц үнэн зөв сургаал хэмээн үзэж, нийгмийн онолын сэтгэлгээг үзэл сурталжуулж байсан
 - E. А болон B хариулт зөв

Боловсролын Үнэлгээний Төв

57. Манай улсыг хэдийд БНМАУ гэж нэрлэж байсан бэ? (1 оноо)
A. 1921 -1990 он B. 1924-1992 он
C. 1924-1990 он D. 1921 оноос одоог хүртэл
E. 1924 оноос одоог хүртэл
58. 1992 оны Үндсэн хуулинд зааснаар аль субъект нь хууль санаачлах эрхтэй вэ? (1 оноо)
A. Ерөнхийлөгч B. Олон нийтийн байгууллага
C. Үндсэн хуулийн цэц D. Хөдөлмөрчид
E. Монгол улсын иргэн

ХОЁРДУГААР ХЭСЭГ

59. XX зуунд манай улс хэдийд хэрхэн нэрлэгдэж ирснийг тохируулна уу. (А, В, С, D, E тус бүрт харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу).
A. Олноо өргөгдсөн Монгол улс 1. 1911-1915 он
B. БНМАУ 2. 1915-1919 он
C. Монгол улс 3. 1921-1924 он
D. Автономит Монгол улс 4. 1924-1992 он
E. Хэмжээт эрхт хаант Монгол улс 5. 1992 оноос хойш
60. Дараах түүхийн дурсгалт газруудын газар нутгийн хамаарлыг тохируулна уу. (А, В, С тус бүрт харгалзах утгыг 1, 2, 3-аас сонгоно уу).
A. Цагаан агуй 1. Хэнтийн Батширээт сум
B. Раашан хад 2. Баянхонгорын Баянлиг сум
C. Хойд Цэнхэрийн агуй 3. Ховдын Манхан сум

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Эртний хүмүүс анх багаж зэвсгүүдээ ямар материалаар хийж байсан вэ? (1 оноо)
A. Төмөр B. Гууль C. Чулуу D. Зэс E. Хүрэл
2. Эртний хүмүүс чuluун зэвсгийн хэд хэдэн үеийг дамжин хөгжжээ. Чuluун зэвсгийн хамгийн сүүлийн шатыг /үеийг/ юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
A. Дунд чuluун зэвсэг B. Эцсийн чuluун зэвсэг
C. Төгсгөлийн чuluун зэвсэг D. Шинэ чuluун зэвсэг
E. Хөгжингүй чuluун зэвсэг
3. Баянхонгор аймгийн Нарийн гол /Уранхайрханы/-ын дурсгал аль үеийн гол дурсгал вэ? (1 оноо)
A. Хуучин чuluун зэвсэг B. Дунд чuluун зэвсэг
C. Хүрэл зэвсгийн үе D. Төмөр зэвсгийн түрүү үе
E. Хүннү
4. Эртний хүмүүсийн хамгийн анх эрхэлж байсан аж ахуй аль нь вэ? (1 оноо)
A. Мал аж ахуй B. Түүвэрлэх аж ахуй
C. Нуудлийн мал аж ахуй D. Газар тариалан
E. Газар тариалан мал аж ахуй
5. Аль нь МЭӨ /НТӨ/ II мянганы I хагаст хамарагдах вэ? (2 оноо)
A. МЭӨ XXVI-XXIX зуун B. МЭӨ XIX-XVI зуун
C. МЭӨ XIV-XI зуун D. МЭӨ XXIV-XXI зуун
E. МЭӨ IX-VI зуун
6. Монгол нутагт өргөн тархсан буган чuluун хөшөө нь аль үед хамарагдах дурсгал вэ? (1 оноо)
A. Хуучин чuluун зэвсэг B. Дунд чuluун зэвсэг
C. Шинэ чuluун зэвсэг D. Хүрэл зэвсгийн үе
E. Хүннү
7. Төр улс үүсэхийн өмнөх нийгмийн зохион байгуулалтын хэлбэр юу вэ? (1 оноо)
A. Эхийн эрхт овог B. Эцгийн эрхт овог
C. Аймаг D. Аймгийн холбоо
E. А ба В зөв

8. Монгол нутагт өргөн тархсан буган хөшөөнд бугыг хэрхэн яж дурсэлсэн байдаг вэ? (1 оноо)
 А. Зөвхөн бодит байдлаар Б. Зөвхөн загварчилж С. Бодитой болон загварчилж
 Д. Улаан зосоор зурж Е. Бэхээр зурж
9. Монгол нутагт үүссэн анхны төрт улс Хүннү хэзээ байгуулагдсан вэ? (1 оноо)
 А. МЭӨ 198 он Б. МЭӨ 209 он С. МЭӨ 109 он
 Д. МЭ 109 он Е. МЭ 93 он
10. Түрэгийн хаад, жанжин нарт зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээс ямар бичгээр /үсгээр/ бичигдсэн байдаг вэ? (1 оноо)
 А. Монгол бичиг Б. Руни бичиг С. Уйгур бичиг
 Д. Согд бичиг Е. Уйгуржин бичиг
11. Доор өгөгдсөн үгүүдийг ямар шалгуураар А болон В хэсэгт хуваан бичсэн байна вэ?
 А) Аравтын систем, хууль дээдлэх, төрийн билэгдэл, татварын тогтолцоо
 Б) Хэв заншил баримтлах, хамтын өмч, цусан төрөл эхийн эрхт ёс (2 оноо)
 А. Овог аймгийн ялгаагаар Б. Соёлын хэлбэрээр
 С. Зан заншилын ялгаагаар Д. Төр ба овгийн зохион байгуулалт
 Е. Угсаа гарлын ялгаагаар
12. Өгөгдсөн эхийг анхааралтай уншина уу. “Сурвалжтанууд малаар төдийгүй арилжааны ашиг, дайны олзоор өмч хөрөнгө, нэр хүнд, нөлөөгөө бэхжүүлдэг байлаа. Дайнаар бусдын мал хөрөнгийг дээрэмдэх, эрхшээлдээ оруулах явдал жирийн хэрэг байв. Төрөл бус хэд хэдэн аймаг цэргийн хүчирхэг удирдагчийн захиргаанд нэгдэж нийгмийн зохион байгуулалтын шинэ хэлбэрийг бий болгожээ. Тэдний дунд ноёлогч аймаг бий болж, аймгуудын зонхилогчдын зөвлөөнөөс тэргүүнээ сонгодог болов”. Дээрх эхэд нийгмийн зохион байгуулалтын аль хэлбэрийн талаар өгүүлж байна вэ? (2 оноо)
 А. Аймгийн холбоо Б. Эхийн эрхт овог С. Эцгийн эрхт овог
 Д. Аймаг Е. Төр улс
13. Өгөгдсөн эхийг анхааралтай уншина уу. “Хүнээ оршуулахдаа нүхээ хавтгай чулуугаар доторлоод, шарилынхаа толгойг зүүн зүг хандуулж, толгой дор нь чулуу дэрлүүлэн дээш харуулж, тэнэгэр байдлаар тавина”. Дээрх эхэд ямар төрлийн булш бунхны оршуулгын зан үйлийн талаар өгүүлж байна вэ? (2 оноо)
 А. Хиригсүүр Б. Сяньбийн булш С. Хүннү булш
 Д. Түрэгийн үеийн булш Е. Дөрвөлжин булш
14. Хүннүгээс уламжлалтай Аравтын тогтолцооны үндсэн шинж юу вэ? (2 оноо)
 А. Цэргийн зохион байгуулалт Б. Засаг захиргааны зохион байгуулалт
 С. Иргэний зохион байгуулалт Д. Цэрэг засаг захиргааны зохион байгуулалт
 Е. В ба С зөв
15. Дунху нар Монголчуудтай угсаа гарлын ямар холбоотой вэ? (2 оноо)
 А. Монгол хэлтэн, Монголчуудын эртний дээд овог
 Б. Түрэг хэлтэн угсаа гарлын холбоогүй
 С. Манж хэлтэн угсаа гарлын холбоогүй
 Д. Монголчуудтай угсаа гарлын холбоогүй ч хожим бүрэлдэхүүнд нь орсон
 Е. Монгол хэлтэн угсаа гарлын холбоогүй
16. Хамаг монголын ханлигийн анхны хаан хэн вэ? (1 оноо)
 А. Хабул Б. Амбагай С. Хотула Д. Тэмүжин Е. Есүхэй
17. Тэмүжин хэдэн онд Хамаг Монголын ханлигийг дахин сэргээн, Чингис цолтойгоор Хамаг Монголын ханлигийн хаанаар өргөмжлөгдсөн вэ? (1 оноо)
 А. 1162 он Б. 1280 он С. 1189 он Д. 1202 он Е. 1206 он
18. Чингис хаан Их Монгол улсыг байгуулаад Го ван /улсын ван/-аар хэнийг томилсон вэ? (1 оноо)
 А. Боорчи Б. Мухурай С. Шихихутаг Д. Зэв Е. Зэлэм
19. Өгөгдсөн эхийг анхааралтай уншаад 23, 24 дахь асуултад хариулна уу. «Чингис хаан (баруун зүг) байлдаанд мордоод, Тангуд улсын Бурханд элч явуулж хэлүүлсэн нь: “Баруун гар чинь больё гэж чи хэлсэн биш үү? Сартаял улсад алтан аргамжаа таслуулаад би хариу авахаар мордов. Баруун гар болж морил” гэж илгээв. Бурхан үг хэлэхийн урьд Аша Хамбу өгүүлрүүн: “Хүч хүрэхгүй бол хаан юунд болов” гээд туслах цэрэг өгсөнгүй омогтой их үг хэлж элчийг буцаажээ». Дээрх эхэд “алтан аргамж” гэж юуны тухай өгүүлж байна вэ? (2 оноо)
 А. Гадаад худалдаа Б. Алт эрдэнэс С. Мал сүрэг
 Д. Цэрэг дайчид Е. Элчин харилцаа
20. Чингис хаан ямар улс руу хийсэн аян дайндаа Тангудын Бурхан хааныг “Баруун гар болж морил” хэмээн цэргээ авч ирж хүч хавсруулахаар элч илгээсэн тухай дээрх эхэд өгүүлж байна вэ? (2 оноо)
 А. Алтан улс Б. Хорезм С. Хар кидан
 Д. Энэтхэг Е. Хятад

Боловсролын Үнэлгээний Төв

21. Доорх эхийг анхааралтай уншина уу. “Их хаан 1248 оны өвөл их цэргээ авч өрнө зүг Эмиль нутагт эмчлүүлнэ хэмээн морджээ. Түүнийг явахад Тулуйн бэлэвсэн хатан Сорхагтани бэхι Батад элч илгээж, сээрэмжтэй байхыг сануулж байв. Бат түүнтэй олон жилийн өмнөөс зөрчилтэй байсан бөгөөд их хаан болоход нь дэмжээгүй билээ. Бат цэргээ бэлтгэн сээрэмжлэн хүлээж байтал 1248 оны хавар их хаан гэнэт нас нөгчжээ”. Дээрх эхэд ямар их хааны (хэний) тухай өгүүлж байна вэ? (2 оноо)
- A. Өгөдэй B. Мөнх C. Гүюг D. Хубилай E. Тулуй
22. XIII зууны үед Монголчуудын хэрэглэж байсан цэрэг захиргааны 10-тын тогтолцоо хэдий үеэс уламжлагдан хөгжиж ирсэн вэ? (1 оноо)
- A. Хүннү B. Сяньби C. Жужан /Нирун/
D. Түрэг E. Уйгур
23. Юан улсын гүйцэтгэн захирамжлах дээд байгууллага аль нь вэ? (1 оноо)
- A. Ерөнхий яам B. Түшмэлийн яам C. Ёслолын яам
D. Дотоод бичгийн яам E. Нууц бичгийн яам
24. Их монгол улсын эхний 4 их хааны хаан суусан он цагийн дэс дарааллыг ол. (2 оноо)
- A. Чингис, Өгөдэй, Мөнх, Хубилай B. Чингис, Өгөдэй, Хубилай, Мөнх
C. Чингис, Өгөдэй, Гүюг, Хубилай D. Чингис, Гүюг, Өгөдэй, Мөнх
E. Чингис, Өгөдэй, Гүюг, Мөнх
25. Халх монголд байгуулагдсан буддын шашны анхны сүм хийд аль нь вэ? (2 оноо)
- A. Гандан B. Заяын хийд C. Амарбаясгалант
D. Ламын гэгээний хийд E. Эрдэнэ зуу
26. Буддын шашин Монгол нутагт нийт гурвантаа дэлгэрсэн ажээ. Дундах буюу хоёр дахь дэлгэрэлт хэдийд эхэлсэн вэ? (2 оноо)
- A. Хүннү B. Жужан /Нирун/ C. XIII зууны II хагаст
D. XVI зууны II хагаст E. Түрэг
27. Түүхийн сурвалжуудад улс төрийн бутралын үеийн тухай өгүүлэхдээ хэрэглэдэг “дөчин, дөрвөн 2 “ хэмээх ямар утгыг илэрхийлдэг вэ? (2 оноо)
- A. Эзэн харьяатын ёс B. Мал сүргийн харьцаа C. Цэргийн зохион байгуулалт
D. Ар, Өвөр Монгол E. Зүүн, баруун Монгол
28. Түүхэн сурвалжид “Бага хаадын үе” гэж тэмдэглэсэн нь аль үеийг хэлж байна вэ? (2 оноо)
- A. Хубилай хааны дараагийн үеийг
B. Манжийн эрхшээлийн үеийг
C. Улс төрийн бутралын үеийг
D. Чингис, Өгөдэй, Гүюг, Мөнх хаанаас бусад хаадын үеийг
E. Чингисээс бусад хаадын үеийг
29. Улс төрийн бутралын үед зүүн монголын 6 түмэн нь дотроо зүүн 3 түмэн, баруун 3 түмэнд хуваагддаг. Зүүн 3 түмнийг хаан захирдаг байсан бол, баруун 3 түмнийг хэн /ямар албан тушаалтан/ захирдаг байсан вэ? (1 оноо)
- A. Тайж B. Чинсан C. Хан D. Жонон E. Ван
30. 1911 онд Монголчууд ямар улсын ноёрхлыг түлхэн унагааж, Төрийн тусгаар тогтолцоо сэргээсэн вэ? (2 оноо)
- A. Хятад B. Манж Чин улс C. Орос
D. Дундад иргэн улс E. Дундад улс
31. 1911.12.29 нд Монголчууд төрийн тусгаар тогтолцоо сэргээн, VIII Богд Жибзундамба хутагтыг хаан ширээнд өргөмжилж, 5 яамыг байгуулжээ. Гадаад яамны тэргүүн сайдаар хэнийг томилсон вэ? (2 оноо)
- A. Да лам Цэрэнчимэд B. Чин ван Ханддорж C. Бэйс Гомбосүрэн
D. Сайн ноён хан Намнансүрэн E. Гүн Цэрэндорж
32. 1686 онд Заг, Байдрагийн Хүрэн бэлчирт болсон чуулганаар ямар асуудлыг хэлэлцсэн вэ? (2 оноо)
- A. Монгол, Ойрадын их цаазыг батлах
B. Халх журам хуулийг батлах
C. Түшээт хан, Засагт хан ноёдыг хооронд нь эвлэрүүлэх
D. Халх, Ойрад хоёр бие даасан улс болохоо харилцан хүлээн зөвшөөрөх
E. Манжид дагаар орох
33. Юан улсын сүүлчийн хаан хэн бэ? (2 оноо)
- A. Тогоонтөмөр B. Лигдэн C. Аюушридар
D. Есөнтөмөр E. Хайсанхүлэг
34. Манай улс хэдийд хэмжээт эрхт /цаазат/ хаант төрийн байгуулалтай байсан вэ? (2 оноо)
- A. 1911-1919 он B. 1911-1921 он C. 1911-1924 он
D. 1921-1924 он E. 1911-1915 он

35. Манж чин улсаас Монголд тогтоосон засаг захиргааны зохион байгуулалтаар сумыг ямар тушаалтан захирч байсан вэ? (2 оноо)
- A. Сумын засаг дарга
 - B. Сумын чуулган дарга
 - C. Чин ван
 - D. Гүн
 - E. Сумын занги
36. Манжаас тогтоосон хуулиар Монголын малчин ардуудыг суман ард, хамжлага ард, шавь ард хэмээн гурав хуваан хамжлагчлааар тогтоожээ. Хамжлага ард нь хэний хамжлага вэ? (2 оноо)
- A. Монголын ноёд язгууртнуудын
 - B. Хутагт хувилгаан
 - C. Манжийн хааны /төрийн/
 - D. Манжийн амбаны
 - E. С ба D зөв
37. 1945.10.20-нд манай улс даяар бүх нийтийн санал хураалт анх удаа явагджээ. Бүх нийтийн санаал хураалтыг ямар асуудлаар явуулсан вэ? (1 оноо)
- A. Монголын тусгаар тогтнолын асуудлаар
 - B. Японд дайн зарлах асуудлаар
 - C. ЗХУ-д нэгдэх асуудлаар
 - D. Хятадад нэгдэх асуудлаар
 - E. Бүх нийтийн сонгуулийн асуудлаар
38. Аль нь манай улсын Бүгд найрамдах байгууллын үеийг зөв илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. 1921-1990 он
 - B. 1924-1990 он
 - C. 1924-1992 он
 - D. 1921 оноос одоог хүртэл
 - E. 1924 оноос одоог хүртэл
39. Манжийн үеэс одоо хүртэл уламжилж ирсэн засаг захиргааны нэгж аль нь вэ? (1 оноо)
- A. Сум
 - B. Дүүрэг
 - C. Хороо
 - D. Нийслэл
 - E. Хошуу
40. 1914 онд байгуулагдсан улсын дээд, доод хурлыг яж /ямар зарчмаар/ байгуулдаг байсан вэ? (2 оноо)
- A. Бүх нийтийн сонгуулиар
 - B. Аймаг хошуудын төлөөллөөр
 - C. Орон нутгийн сонгуулиар
 - D. Гол төлөв язгуур угсаа, албан тушаалын зэрэглэлийг баримтлан
 - E. Сонгуулийн насны эрчүүдийн санаалаар
41. 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Монголын тусгаар тогтнолын асуудлыг хэрхэн шийдсэн бэ? (2 оноо)
- A. Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
 - B. Нийт Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
 - C. Нийт Монголд Хятадын харьяаны автономит эрх олгосон
 - D. Зөвхөн Ар Монголд Хятадын харьяаны автономит эрх олгосон
 - E. Нийт Монголыг Хятадын харьяаны жирийн муж болгосон
42. Консулын дэнжийн нууц бүлгээнийг хэн санаачлан байгуулсан вэ? (1 оноо)
- A. Д.Бодоо
 - B. Д.Сүхбаатар
 - C. С.Данзан
 - D. Х.Чойбалсан
 - E. Д.Догсом
43. Манай улсад жил бүрийн 11 сарын 26-ыг улс тунхагласны баярын өдөр болгон тэмдэглэдэг. Түүхэн ямар үйл явдалтай холбогдуулан энэ баярыг тэмдэглэдэг вэ? (2 оноо)
- A. 1911.11.26 -нд Богд хаант Монгол улс байгуулагдсан
 - B. 1912.11.26-нд гадаадын 9 улсад нот бичиг илгээн, тусгаар тогтнолоо зарласан
 - C. 1921.11.26-нд гадаадын 9 улсад нот бичиг илгээн, тусгаар тогтнолоо зарласан
 - D. 1924.11.26-нд анхдугаар Үндсэн хуулийг баталж, бүгд найрамдах байгуулал тогтсон
 - E. 1945.11.26-нд Орос, Хятад хоёр улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
44. Олноо өргөгдсөн Монгол улсын тусгаар тогтнолыг хамгийн анх хүлээн зөвшөөрсөн орон аль нь вэ? (2 оноо)
- A. Хятад
 - B. Орос
 - C. Япон
 - D. Энэтхэг
 - E. Түвэд
45. 1921 оны хувьсгалын дараа нийгмийг ардчилах олон арга хэмжээ авчээ. “Нутгийн захиргааны дүрэм”-ээр ямар гол өөрчлөлт хийгдсэн вэ? (2 оноо)
- A. Засаг захиргааны хуваарыт өөрчлөлт хийсэн
 - B. Аймгийн нэрийг газар усны нэрээр нэрлэх болсон
 - C. Орон нутгийн хурлуудыг байгуулж, удирдлагыг нь сонгодог болсон
 - D. Засаг захиргааны гол нэгж болох хошууг татан буулгасан
 - E. Их шавийг татан буулгасан
46. Өгөгдсөн эхийг анхааралтай уншаад 46, 47 дахь асуултад хариулна уу. “Монгол улсын Богд хаан Жибзундамба хутагтад шарын шашны бүх хэргийг хязгааргүй эрхлэх эрхийг үлдээж, Ардын засгийн газраас тогтоон явуулах аливаа хууль дүрмийг Богд хаантанд айлтгэн сонсгох хэдий ч хууль дүрмийг Богд зөвхөн нэг удаагаас илүү буцаах, хүчингүй болгох эрхгүй онцлон заажээ”. Ямар баримт бичгийн (эрх зүйн актын) гол агуулгын талаар дээрх эхэд өгүүлж байна вэ? (2 оноо)
- A. Үндсэн хууль
 - B. Тангаргийн гэрээ
 - C. Засгийн газрын гэрээ
 - D. Богдын эрхийг хэмжээлсэн дүрэм
 - E. Ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм

Боловсролын Үндэлгээний Төв

47. Дээрх баримт бичиг (эрх зүйн акт) батлагдсанаар Монголд төрийн ямар хэлбэр тогтсон бэ? (2 оноо)
- A. Бүгд найрамдах байгуулал
 - B. Парламентын Бүгд найрамдах байгуулал
 - C. Ерөнхийлөгчийн Бүгд найрамдах байгуулал
 - D. Хэмжээгүй эрхт хаант төрийн байгуулал
 - E. Хэмжээт эрхт хаант төрийн байгуулал
48. “Бусдыг мөлжихгүйгээр хэм тэгш баяжигтун” уриаг хэдийд, ямар үзэл баримтлагчид дэвшүүлсэн вэ? (2 оноо)
- A. 1920-иод оны 2 хагаст үндэсний ардчилсан үзэл баримтлагчид
 - B. 1929-1932 оны үед зүүнтнүүд
 - C. 1920-иод оны эхэн үед капитализмын замаар замнагчид
 - D. 1911-1919 онд Монголын удирдагчид
 - E. 1940-өөдөн онд Чойбалсан
49. Өгөгдсөн эхийг анхааралтай уншина уу. «“Мөнөөхөн ардыг мөлжиж, хөрөнгө зоорь хураасан ван, гүн, хутагт, сүм, жас, баячууд, шинэ хөрөнгөтөн, панзчин нарын хэтэрхий хөрөнгөжих замыг хязгаарлах, ... тэдгээрийн хөрөнгийг бүр мөсөн буюу заримыг нь хураах” тухай шийдвэр гаргасны дагуу хар, шар “феодал” агсадын хөрөнгө хураах үйл явдал эхэлжээ». Дээрх эхэд өгүүлж байгаа “феодал” агсадын хөрөнгийг хураах ажиллагаа хэдийд болсон бэ? (2 оноо)
- A. 1921 -1924 он
 - B. 1924-1928 он
 - C. 1929-1932 он
 - D. 1932-1934 он
 - E. 1924-1926 он
50. 1933 онд Сайд нарын Зөвлөлийн тогтоол гаргаж, улмаар “Төрөөс шашныг тусгаарлах тухай хууль”-аар 18 нас хүрээгүй хүүхдийг хийдэд шавилан суухыг хориглосны гол учир юу вэ? (2 оноо)
- A. Хүүхдийн эрхийг хамгаалах
 - B. Хийдэд шавилан суугчдын тоог цөөрүүлж, улмаар сүм хийдийг шахах
 - C. Сургуулийн хүүхдийн тоог нэмэгдүүлэх
 - D. Цэргийн тоог нэмэгдүүлэх
 - E. А болон D хариулт зөв
51. Өгөгдсөн эхийг анхааралтай уншина уу. “1937.08.24-нд ЗХУ-ын ДХАК (ДЯЯ)-ын орлогч сайд М.П.Фриновский, БХЯ-ны орлогч сайд Смирнов нар Монголд ирж, Японоос Монголыг эзлэх төлөвлөгөө гэгчийг Монголын удирдагчдад танилцуулж, “хуйвалдаан” гэгч хэрэгт холбогдсон 115 хүний нэрсийн жагсаалтыг ДЯЯ-ны сайд Х. Чойбалсанд гардуулсан байна. Ингээд 1939.IX.10-ны шөнө ЗХУ-ын ДХАК-ын газраас ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу цэрэг, төр захиргаа, соёлын салбарын ажилтан 69 хүнийг нэгэн зэрэг баривчилснаар Монгол орныг нийтэд нь хамарсан их залхаан цээрлүүлэлт, нийтээр хоморголон хэлмэгдүүлэх ажиллагаа эхэлсэн байна”. Эхийг уншаад дараах дүгнэлт хийжээ. Аль дүгнэлт нь тухайн үеийн түүхэн нөхцөл байдлыг илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Монголд Японы тагнуулын байгууллага байсныг илрүүлсэн
 - B. Монголд Зөвлөлтийн эсрэг “хуйвалдаан” хийх зорилготой нууц байгууллага байсан
 - C. Монголын ДЯЯ муу ажиллаж байсан
 - D. Монгол дахь хэлмэгдүүлэлтийг ЗХУ-аас санаачлан зохион байгуулсан
 - E. А ба В хариулт зөв
52. Газар бол улсын үндэс хэмээх төр ёсны уламжлалын зарчмыг хэрхэн үндэслэсэн бэ? (2 оноо)
- A. Модун
 - B. Таньшихуай
 - C. Хабул хан
 - D. Моюонхуай
 - E. Чингис хаан
53. Их Монгол улсын төрийн дээд эрх хэний мэдэлд байсан бэ? (1 оноо)
- A. Их хуралдай
 - B. Сэцдийн зөвлөл
 - C. Улсын ван
 - D. Эзэн хаан
 - E. Алтан ураг
54. “БНМАУ-ын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол ... МАХН мөн” гэсэн 1960 оны Үндсэн хуулийн заалтын мөн чанарыг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Нэг намын ноёрхлыг гүнзгийрүүлж, нам төвтэй улс төрийн тогтолцоо тогтох эрх зүйн үндэс болсон
 - B. МАХН-ын үүргийг дээшлүүлсэн
 - C. Төрийн үүргийг бууруулсан
 - D. Ганц намын тогтолцоотой байх эрх зүйн үндэс болсон
 - E. МАХН-аас өөр нам байгуулагдах эрх зүйн үндсийг үгүйсгэсэн
55. «1956 онд “Манай намын бодлогод харш үзэл санаа, үг, өгүүлэл гарч байгаа тухай”, 1959 онд “Б.Ринчингийн сүүлийн үеийн зохиолууд дахь зарим харш үзэл санааны тухай” зэрэг Намын Төв Хорооны тогтоол гарч» 1959 онд Д.Дамба нарыг “хоцрогдсон”, 1962 онд Д.Төмөр-Очирыг “намын эсрэг явуулга хийсэн”, 1963 онд

- Л.Цэндийг “намч биш”, Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарыг “намын эсрэг бүлэглэсэн” хэмээн нам, төрийн удирдлагаас зайлцуулжээ». Дээрх баримтад тулгуурлан дараах дүгнэлтийг хийжээ. Аль дүгнэлт нь тухайн үеийн нөхцөл байдлыг илүү оновчтой илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Тухайн үед Монголд үндсэрхэг, үгүйсгэх үзэлтнүүд олон байсан
 - B. Тухайн үед социализмыг эсэргүүцсэн, “намын эсрэг бүлэглэсэн” ўйл ажиллагаа явуулсан бүлэглэлүүд байсан
 - C. Эдгээр хүмүүсийг нам, төрийн удирдлагаас зайлцуулснаар Монголд авторитари дэглэм тогтсон
 - D. Дээр нэр нь дурдагдсан хүмүүс хоцрогдсон, үндсэрхэг, үгүйсгэх үзэлтнүүд байсан
 - E. А болон В хариулт зөв
56. 1992 оны Үндсэн хуулинд зааснаар аль субъект нь хууль санаачлах эрхтэй вэ? (1 оноо)
- | | | |
|----------------------------|-----------------------|-----------------------|
| A. Засгийн газар | B. Монгол улсын иргэн | C. Үндсэн хуулийн цэц |
| D. Олон нийтийн байгуулага | E. Хөдөлмөрчид | |
57. Монгол нутаг дах эртний улсуудаас цэрэг, засаг захиргааны аравтын тогтолцоог ямар улс анх хэрэглэсэн бэ? (1 оноо)
- | | | | | |
|----------|-----------|------------------|----------|----------|
| A. Хүннү | B. Сяньби | C. Жужан (Нирун) | D. Түрэг | E. Уйгур |
|----------|-----------|------------------|----------|----------|
58. 1992 оны үндсэн хуулинд зааснаар аль субъект нь хууль санаачлах эрхтэй вэ? (2 оноо)
- | | |
|-----------------------------|-----------------------|
| A. Ерөнхийлөгч | B. Монгол улсын иргэн |
| C. Олон нийтийн байгууллага | D. Хөдөлмөрчид |
| E. Үндсэн хуулийн цэц | |

ХОЁРДУГААР ХЭСЭГ

59. Дараах түүхийн дурсгалууд аль үед хамаарахыг тохируулна уу? (A, B, C, D, E тус бүрт харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу).
- | | |
|------------------------------------|-------------------------|
| A. Дорнодын Тамсагбулагийн дурсгал | 1. Хуучин чулуун зэвсэг |
| B. Культегиний гэрэлт хөшөө | 2. Шинэ чулуун зэвсэг |
| C. Ховдын Хойд Цэнхэрийн агуй | 3. Хүннүгийн үе |
| D. Ноён уулын соёл | 4. Түрэгийн үе |
| E. Дөрвөлжин булаш | 5. Хүрэл, төмрийн үе |
60. Монголчууд түүхэндээ олон бичиг үсэг зохион хэрэглэж байжээ. Ямар бичиг үсгийг хэн зохиосныг тохируулна уу. (A, B, C тус бүрт харгалзах утгыг 1, 2, 3-аас сонгоно уу.)
- | | |
|-------------------|---------------------------|
| A. Дөрвөлжин үсэг | 1. Өндөр гэгээн Занабазар |
| B. Тод үсэг | 2. Зая бандид Намхайжамц |
| C. Соёмбо үсэг | 3. Пагва лам |

2006 оны Монгол улсын түүхийн хичээлийн даалгаврын түлхүүр

№	Хувилбар		
	A	B	C
1	A	A	C
2	B	A	D
3	A	D	A
4	D	D	B
5	C	D	B
6	E	D	D
7	D	D	D
8	E	C	C
9	D	B	B
10	A	B	B
11	C	E	D
12	B	B	A
13	E	D	E
14	D	D	D
15	D	A	A
16	C	C	A
17	B	C	C
18	E	C	B
19	A	B	E
20	C	E	B
21	B	C	C
22	B	B	A
23	D	E	D
24	B	B	E
25	C	B	E
26	E	A	C
27	E	C	E
28	C	B	C
29	C	C	D
30	B	B	B
31	C	A	B
32	D	D	C
33	C	C	A
34	E	D	D
35	D	A	E
36	A	C	A
37	C	E	A
38	B	E	C
39	D	D	A
40	D	C	D
41	A	D	D
42	D	C	A
43	D	D	D
44	B	D	E

№	Хувилбар		
	A	B	C
45	A	D	C
46	D	A	B
47	C	C	E
48	B	B	A
49	D	D	C
50	D	D	B
51	A	A	D
52	A	A	A
53	C	C	D
54	A	E	A
55	A	C	C
56	D	D	A
57	A	B	A
58	B	A	A
59	A-2	A-1	A-2
	B-4	B-4	B-4
	C-1	C-5	C-1
	D-3	D-2	D-3
	E-5	E-3	E-5
60	A-3	A-2	A-3
	B-2	B-1	B-2
	C-1	C-3	C-1

